Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ... дугаар сарын ... -ны өдрийн....
дугаар албан бичгийн ...... дугаар хавсралт

# НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 11 дүгээр сарын 25 Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Зорилтот түвшин | Батлагдсан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | | | | | |
| **НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | |
| **1.4.2 Нийтийн тээвэр, логистик** | | | | | | | | | | | | | |
| 103 | НХТЖҮ Ч-9.22.2 | Цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх дэд станц барих бэлтгэл хангах | НТБГ, ЗТ-2 ОНӨҮГ | НТ | 2023 | - | Зураг төсөл боловсруулах ажлын явц | хувь | 100 | 300.0 | - | Цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах зураг, төслийг боловсруулан, хамтран ажиллах тухай саналыг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны 01/07/33 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Бодлогын судалгаа, шинжилгээний төвд БНСУ-ын Кёнсанбуг мужийн холбогдох албан тушаалтан хүрэлцэн ирж, цахилгаан автобус, цэнэглэх станц, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон карбон кредит төслийн талаар танилцуулсан. уулзалтад тус газрын удирдлагууд оролцож санал бодлоо солилцсон. | 100 |
| | | | НТБГ | НТ | 2024 | 1,100 | Шинээр үйлчилгээд нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл | тоо | 297 | 89,100.0 | - | Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Юутонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу Yutong ZK6117H загварын их багтаамжийн MNS 4598:2011 стандартын 8.1.1 "Улс хоорондын, хот хоорондын, хот орчмын үйлчилгээнд ажиллах автобус нь 1-ээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар олон суудал, гар тээшний тавиураар тоноглогдсон, тээш хадгалах хонгил байна" гэх шаардлагыг хангасан 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Х:18 "Тэнгэр плаза-Багахангай" чиглэлд, 4 дүгээр сарын 30-ны өдрөөс Х:17 "Тэнгэр плаза-Багануур", 05 дугаар сарын 02-ны өдрөөс Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар" чиглэлд үйлчилгээнд нэвтрүүлсэн.<br>Skywell маркийн 15 цахилгаан автобусыг нийтийн тээврийн үйлчилгээний Ч:42, Ч:58, Ч:57 чиглэлүүдэд 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс үйлчилгээнд гаргасан.<br>Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн Yutong маркийн дизель евро-5 хөдөлгүүртэй хот орчмын 10, skywell маркийн 15, zinhui маркийн 2, нийт 27 автобусаар парк шинэчлэлт хийсэн.<br>Хувийн хэвшлийн 6 аж ахуйн нэгж, байгууллага их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 84 автобусаар нөхөн хангалт хийсэн. | 71 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| [illegible] | | ...нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх | НТБГ | НТ | | | Байгальд ээлтэй цахилгаан автобусны хүртээмжийг нэмэгдүүлнэ | тоо | | 11,000.0 | 11,000.0 | Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 192/ШШ2025/05784 дүгээр шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын "Шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай" 2025.09.26-ны өдрийн А/1349 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж захиалагчийн хяналтыг тавьж ажилласан. Үүний дагуу БНХАУ-д 2023 онд үйлдвэрлэгдсэн SKYWELL NJL6106BEV загварын их багтаамжийн 15 ширхэг бүрэн цахилгаан автобус болон 11 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжүүдийг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авах ажлыг хоёр үе шаттай зохион байгуулсан. 11 ширхэг автобус цэнэглэгч төхөөрөмжийг 2025 оны 10 дугаар сарын 16-ний өдөр "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ-т актаар хүлээлгэн өгсөн. Их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй 15 ширхэг автобус нь дараах чиглэлүүдэд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байна. Үүнд: Ч:25,Ч:28, Ч:39, Ч:42, Ч:57, Ч:57Б, ШҮ:1, М:1, М:2, М:4 , М:5, М:3,Х:1, Х:14, Ч:29А 14 чиглэлд 15 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй автобуснууд хэвийн үйл ажиллагаа явуулж байна. | 100 |
| | | | НТБГ | - | 2023 | 1,000 | Өдөрт гарах тээврийн хэрэгсэл | тоо | 1,301 | - | 0 | 2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 138 чиглэлд ажлын өдөр 1180, амралтын өдөр 1006 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь өдөрт үйлчлэх тээврийн хэрэгслийн гаралт 2023 оны суурь түвшин 1000 тээврийн хэрэгслийн гаралттай харьцуулахад 18%-иар, 2024 оны суурь түвшинөөс 47 тээврийн хэрэгслийн гаралтаар буюу 4.1%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 106 | (МУХТ-2025 - 7.1.2) НХТЖҮ Ч-9.21.3 | Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх | НТБГ | - | 2023 | 15 | Чиглэлийн тоо | тоо | 20 | - | 0 | Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Юутонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын их багтаамжийн 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авч, Багануур болон Багахангай дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг хангах үүднээс Х:17 Тэнгэр плаза-Багануур, Х:18 Тэнгэр плаза-Багахангай чиглэлийн үйлчилгээнд нийт 3 тээврийн хэрэгсэл, Чингис хаан олон улсын нисэх буудал руу Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар", ШҮ:4 "Сүхбаатарын талбай-Чингис хаан ОУНБ" гэсэн 3 чиглэлд нийт 7 тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлсэн. | 100 |
| 107 | (МУХТ-2025 - 7.1.2) НХТЖҮ | Гэр хорооллын 5 чиглэлд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх | НТБГ | - | 2023 | - | Чиглэлийн тоо | тоо | 5 | - | - | Нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр баригдсан гэр хорооллын дундах авто замын нөхцөл байдлыг судалж холбогдох төлөвлөлтийг боловсруулсан. Судалгаагаар СХД-ийн 14, 21, 31, 43-р хороо БГД-ийн 10, 22-р хороо, БЗД-ийн 17,18,19,27-р хорооны 11 байршилд дунд оврын тээврийн хэрэгслээр үйлчилгээг хүргэх боломжтой байна гэж дүгнэж холбогдох төлөвлөлтийг боловсруулсан. Сонгинохайрхан дүүргийн 31 дүгээр хорооны иргэдийн нийтийн тээврээр зорчих эрэлтийг хангах зорилгоор судалгаа хийж, чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан тус газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Д:4 "Хайрханы шинэ эцэс-Алтай-Цамбагарав-176-р цэцэрлэг" чиглэлийн замналд өөрчлөлт оруулан 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс дунд багтаамжийн 1 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн. Мөн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор Баянзүрх дүүргийн 10, 24, 35 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээ хүрээгүй суурьшлын бүсийн авто замын нөхцөл байдал, зорчих эрэлтийн судалгаа хийж, чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан тус газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/106 дугаар тушаалаар Д:1 "Шархад-Хангамж-Ботаник", Д:11 "Офицеруудын ордон-Цахлай-Баянзүрх дүүргийн 24-р хороо", Д:12 "Баянзүрх дүүргийн 35 дугаар хороо-Улиастайн шинэ эцэс", Д:13 "Улиастайн шинэ эцэс-Шархадны эцэс" чиглэлүүдийн замналыг баталж, 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс дунд багтаамжийн 7 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 108 | Ч-9.21.3 | Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох | НТБГ | - | 2023 | 139 | Нэмэгдүүлэх зорчигч | тоо, сая/жилд | 173 | - | - | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар хуралдаанаар Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах 25/14 дүгээр тогтоолыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж иргэд 1000 төгрөгөөр хугацаа харгалзахгүйгээр өдөрт 4 удаа зорчих боломжтой болсон. Нийтийн тээврээр зорчсон төлбөрийг зориулалтын картаас гадна банкны карт, гар утасны аппликейшн, QR код, бэлэн мөнгөөр төлөх боломжийг бүрдүүлэн ажилласнаар Нийтийн тээврийг хөгжүүлэх санд 2025 оны эхний 10 сарын байдлаар 2024 онд их багтаамжийн автобус худалдан авсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас "Нийтийн тээврийн хэрэгслийг төлбөртэй ашиглуулах гэрээ"-ний дагуу 9,023.3 сая төгрөг, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын санхүүжилтээс элэгдлийн зардалд 17,727.0 сая төгрөг, нийт 26,750.3 сая төгрөг төгрөгийг суутгаж, мөн улсын төсвийн хөрөнгөөр 2009 онд худалдан авсан 400 ширхэг автобусны өр төлбөрөөс автобус худалдан авсан Сутайн буянт ХХК, Автобус нэгдэл ХХК, Эрдэмтранс ХХК нийт 324.0 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Дээрх санд төвлөрсөн орлогоос 2025 онд хот орчмын зориулалттай их багтаамжийн 10 автобус, тусгай тоноглолтой 2 автобус, их багтаамжийн цахилгаан 15 ширхэг автобус, 11 ширхэг цэнэглэх төхөөрөмж, зогсоолын чиглэлийн мэдээллийн зураглалын үнэ төлбөр зэргийг шийдвэрлэсэн. | 100 |
| | | Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох | НТБГ | - | 2023 | 139 | Нэмэгдүүлэх зорчигч | тоо, сая/жилд | 173 | - | - | Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын зардлын санхүүжилтийг "Үр дүнд суурилсан үнэлгээ" /KPI/ тогтолцоонд шилжүүлэх цогц арга хэмжээ авах тооцоо судалгаа хийж, санал боловсруулж, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/344 дугаар захирамжаар Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайгаар ахлуулан байгуулсан, Ажлын хэсэг 2025 оны 03 дугаар сарын 15, 04 дүгээр сарын 15, 08 дугаар сарын 19-ний өдрүүдэд Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл, салбарын холбоодын төлөөлөлтэй уулзаж "Үр дүнд суурилсан үнэлгээ"-ний талаар мэдээлэл өгч, санал солилцсон. "Үр дүнд суурилсан үнэлгээ" (KPI) тогтолцоонд шилжүүлэх системийн нэмэлт хөгжүүлэлтийг Улаанбаатар смарт карт ХХК, Ай Си Ти групп ХК-ийн системүүдэд хийгдэж эхлээд байна. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын зардлын санхүүжилтийг "Үр дүнд суурилсан үнэлгээ" /KPI/ тогтолцоонд шилжүүлэх ажлын ачаалал, хяналтын чиг үүргээс хамаарч Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайгийн саналаар ажлын хэсгийн ахлагчаар Автозамын түгжрэлийг бууруулах төсөл, хөтөлбөрийн зохицуулагч Д.Бадарсанг ажиллуулах саналыг гаргаж, захирамжид өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 109 | Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох | НТБГ | - | 2023 | 15 | Хүлээлтийн хугацааны бууралт | минут | 13 | - | - | Нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 138 чиглэлд 1180 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Үндсэн чиглэлүүдийн үйлчилгээний дундаж хүлээгдлийн хугацаа 10.1 минут байгаа нь 2023 оны суурь түвшинтэй харьцуулахад 33%-иар буурсан үзүүлэлттэй байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/405 дугаар захирамжаар байгуулагдсан "Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн сүлжээ төлөвлөлтийг судалж, санал, дүгнэлт боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Түгжрэлээс шалтгаалсан нийтийн тээврийн хүлээгдлийн хугацааг багасгах зорилгоор богино эргэлтийн чиглэлүүдийг төлөвлөх ажлыг эхлүүлсэн. Үүнд: Энхтайваны өргөн чөлөө дагуу М:1а "ХМК- Мөнгөн завьяа", М:1б "Ботаник- Сүхбаатарын талбай" чиглэлийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр нээсэн. Мөн Хан-Уул дүүрэгт зорчдог иргэдийн нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор богино эргэлтийн Ч:7А "Нисэх-5 Богд компани", М:3А "Архивын ерөнхий газар-Таван богд компани" чиглэлийн үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс шинээр нээж үйлчилгээнд гаргасан. Тайлант хугацаанд зорчих эрэлт, зорчигч урсгалын тооцоо судалгаанд үндэслэн нийт 14 чиглэл шинээр нээж, 16 чиглэлд өөрчлөлт оруулсан байна. Үүнээс богино эргэлтийн 14 чиглэл байна. Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны дарга, Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-ын захирал нарын хамтарсан А/72, А/78, А/34 дугаар тушаалаар чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолыг чөлөөлөх, замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий шуурхай ажиллагааны баг байгуулагдаж 2025 оны 08 дугаар сарын 18-аас 09 дүгээр сарын 19-ний өдрийг дуусталх хугацаанд Нийтийн тээврийн бодлогын газрын 51 албан хаагч ажилласан. Дээрх ажлын хүрээнд хамтарсан багийн гишүүд бодит цагийн байдлаар замын хөдөлгөөний нөхцөл байдалд телекамераар хяналт тавьж замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг зохицуулан, нийтийн тээврийн хэрэгслийг авто замын нэгдүгээр эгнээгээр чөлөөтэй нэвтрүүлэх зохицуулалтыг тухай бүр хийснээр Энхтайваны өргөн чөлөө дагуух нийтийн тээврийн хэрэгслийн ашиглалтын дундаж хурд 10.6 км/цаг байсан нь 12.9 км/цаг болж 18%-иар өссөн зэрэг үр дүн гарсан. | 100 |
| 110 | Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх | НТБГ | - | 2024 | 996 | Тавцан төхөөрөмжтэй тээврийн хэрэгсэл | тоо | 297 | - | | 2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийн тээврийн бүртгэлийн санд 1311 тээврийн хэрэгсэл байгаагаас 76.9% буюу 1009 автобус нь тэргэнцэртэй иргэдэд зориулагдсан нам шалтай, тусгай зориулалтын зорчигчийн хэсэг, бэхэлгээ хийгдсэн, дуут зарлан мэдээлэгч, лед дэлгэц, хяналтын камер зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэний зорчих нөхцөлийг хангасан тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Тоноглогдсон тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл Skywell - 96, Golden dragon - 282, Yutong - 631 байна. Үүнээс Yutong - 631 автобус нь харааны бэрхшээлтэй иргэдэд дуут зарлан мэдээлэгч тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. | 100 |
| | Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих | НТБГ, БНДЗДТГ | НТ | 2023 | - | Барилгын ажлын явц | хувь | 100 | 3,500.0 | 1 ,000.0 | Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гараашийн барилгын зураг төслийг 2022 онд "Эрхэс констракшн" ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектураар батлуулсан.<br>Багануур дүүргийн "Тээвэр зохицуулалтын алба" ААТҮГ-ын Нийтийн тээврийн гараашийн барилга барих ажлыг 2025 онд эхлүүлэхээр 1 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр "Наран босголт" ХХК шалгарсан. Тус компани барилгын ажлыг эхлүүлэхээр болсон ч их багтаамжийн автобус гарааш руу орох, гарах үед зай талбай хүрэлцэхгүй байсан тул байршлын схемийн хуудаст заасан координатыг 3-4 метр зөөж шилжүүлэхээр Багануур дүүргийн Засаг Даргын Тамгын Газраас Хот байгуулалт, хотын стандартын газарт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 04/441 дүгээр албан бичгээр хүсэлт хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 111 | | Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих | НТБГ, БНДЗДТГ | НТ | 2023 | - | Барилгын ажлын явц | хувь | 100 | 3,500.0 | 1 ,000.0 | Орон нутгийн төсвийн 3,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гараашны барилгын зураг төслийг 2022 онд "Эрхэс констракшн" ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектураар батлуулсан.<br>Багануур дүүргийн "Тээвэр зохицуулалтын алба" ААТҮГ-ын Нийтийн тээврийн гараашны барилга барих ажлыг 2025 онд эхлүүлэхээр 1 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр "Наран босголт" ХХК шалгарсан.<br>Ажлын явц 35 хувийн гүйцэтгэлттэй байна. Үүнд:<br>- Төмөр бетон карказ угсралтын ажил дууссан.<br>- Дээвэр хийх ажил дууссан.<br>- Төмөр багана, дам нуруу, холбоос угсрах ажлууд дууссан.<br>Мөн Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай 2025.08.24-ний өдөр Багануур дүүрэгт ажиллаж нийслэлийн төсвийн 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй том оврын 10 автобус багтаах чадалтай нийтийн тээврийн дулаан авто зогсоолын барилгын явцтай танилцсан. | |
| Хэрэгжилтийн дундаж хувь: /100*8+71*1/ | | | | | | | | | | | | | 96.7 |

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Г.ЦОЛМОНГЭРЭЛ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ... дугаар сарын ....-ны өдрийн...
дугаар албан бичгийн ...... дугаар хавсралт

# НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 11 дүгээр сарын 25 — Улаанбаатар хот

| № | Үр дүн | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Мэдээллийн эх сурвалж | Мэдээлэл цуглуулах арга зүй | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | он | түвшин | | | | | |
| САЛБАРЫН ҮР ДҮН | | | | | | | | | | |
| 10 | Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог 24 хувиар нэмэгдүүлнэ. | Нийтийн тээврээр үйлчлүүлсэн зорчигчид | жилд, сая | 2023 | 139 | 173 | Жилийн тайлан | Жилд 1 удаа | 2025 оны 11 дүгээр сарын 16-ны байдлаар өссөн дүнгээр 141.3 сая зорчигчдод үйлчилгээ үзүүлээд байна. Өнгөрсөн оны мөн үе буюу 2024 оны 11 дүгээр сартай харьцуулахад 12.7%, суурь түвшинтэй харьцуулахад 6.7%-иар өссөн үзүүлэлттэй байна. | 50 |
| 28 | Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг 30 хувиар нэмэгдүүлнэ. | Өдөрт үйлчилгээнд гарах тээврийн хэрэгсэл | тоо | 2023 | 1000 | 1301 | Жилийн тайлан | Жилд 1 удаа | Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний 138 чиглэлд ажлын өдөр 1180, амралтын өдөр 1006 тээврийн хэрэгсэл, 1280 автобусны зогсоолыг дайран өнгөрч өдөрт 550-650 мянган зорчигчдод үйлчилгээ үзүүлж байна. 2023 оны суурь түвшинтэй харьцуулахад 18%-иар өссөн үзүүлэлттэй байна. | 70 |
| Хэрэгжилтийн дундаж хувь: /70*1+50*1/ | | | | | | | | | | 60 |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ТАЙЛАН, МЭДЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН Г.ЦОЛМОНГЭРЭЛ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ...дугаар сарын....-ны өдрийн .......
дугаар албан бичгийн.... дугаар хавсралт

# НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2025 оны 11 дүгээр сарын 25 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу "НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС"-ийн үйл ажиллагаанд тусгагдсан тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар гарган дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тус газраас 9 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилтийн дунджийг 96.7 хувиар тооцлоо. Үүнээс 85 хувь буюу түүнээс дээш "Үр дүнтэй" 8 арга хэмжээ, 60-84 хувь буюу "үр дүн хүлээгдэж байгаа" 1 арга хэмжээ байна.

"Бодлогын баримт бичгийн 9.22.2 "Шинээр үйлчилгээд нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл" гэсэн арга хэмжээний 71 хувийн биелэлттэй байгаа бөгөөд тухайн онд парк шинэчлэлт хийсэн автобус болон насжилтаар хасагдсан 84 тээврийн хэрэгслээр нөхөн хангалт хийж 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Х:18 "Тэнгэр плаза-Багахангай" чиглэлд, 4 дүгээр сарын 30-ны өдрөөс Х:17 "Тэнгэр плаза-Багануур", 05 дугаар сарын 02-ны өдрөөс Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар" чиглэлд үйлчилгээнд явуулсан. Энэ нь зорилтот түвшний 71 хувьд хүрсэн үзүүлэлт юм.

## ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой тайлагнахыг холбогдох ажлын хэсгийн гишүүд болон хэлтсүүдэд үүрэгжүүлэх саналтай байна. "Үр дүн хүлээгдэж байгаа" арга хэмжээ буюу "Бодлогын баримт бичгийн 9.22.2 "Шинээр үйлчилгээд нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл арга хэмжээний зорилтот түвшин 297 байгаа бөгөөд дахин парк шинэчлэлтийн ажил хийгдэхгүй насжилтаар хасагдах тээврийн хэрэгслээр нөхөн хангалт хийгдэх учир тухайн арга хэмжээний зорилтот түвшинд хүрэхгүй байх магадлалтай.

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХТҮ6986 9024050915 2117428

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН:
ТАЙЛАН, МЭДЭЭ
ХАРИУЦСАН АЖИЛТАН Г.ЦОЛМОНГЭРЭЛ

# НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НОТЛОХ БАРИМТ

2025 оны 11 дүгээр сарын 25 Улаанбаатар хот

Цахилгаан эх үүсвэрээр ажилладаг нийтийн тээврийн хэрэгслийг цэнэглэх цэгүүдийн байршлыг тодорхойлж цэгүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр нийтийн тээврийн парк шинэчлэлт, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийн бодлогын хүрээнд цахилгаан хөдөлгүүртэй автобус нэвтрүүлэх чиглэлээр тооцоо, судалгаа хийж, санал боловсруулах "Ажлын хэсэг байгуулах тухай" А/190 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний 25 зогсоол орчим цахилгаан автобус цэнэглэх цэг байгуулах схем зураг бүхий саналыг Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-д 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 2/253 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.




*Зураг №1*

Дээрх саналын хүрээнд цахилгаан автобусыг цэнэглэх цэгийн газрын байршил, цахилгаан эх үүсвэр, зэрэг бусад нөлөөлөх хүчин зүйлийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран Зорчигч Тээврийн Нэгтгэл ОНӨААТҮГ, Зорчигч Тээвэр Гурав ОНӨААТҮГ судлах ажлыг хийж байна.

Мөн Зорчигч Тээврийн Нэгтгэл ОНӨААТҮГ-т 2 ширхэг цахилгаан автобус цэнэглэх станц, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ -ын бааз дээр нийт 11 ширхэг станц, СБД-ийн 16-р хороо Тоосгоны эцсийн автобусны зогсоол, 20-р хороо Сэлбийн автобусны эцсийн зогсоол, Налайх дүүргийн 2-р хорооны автобусны эцсийн зогсоолд тус бүр 0.4 КВА хүчдэл өргөх ЦТП-г угсарсан 3 ширхэг станц байгуулсан бөгөөд нийт 16 цэнэглэх станцаар нийтийн тээврийн үйлчилгээнд гарч буй 54 цахилгаан автобусны цэнэглэлтийг хийж байна.



*Зураг №2 Цахилгаан цэнэглэх төхөөрөмж*



*Зураг №3 Цахилгаан автобус*

**Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх**

2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 138 чиглэлд ажлын өдөр 1180, амралтын өдөр 1006 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь өдөрт үйлчлэх тээврийн хэрэгслийн гаралт 2023 оны суурь түвшин 1000 тээврийн хэрэгслийн гаралттай харьцуулахад 18%-иар, 2024 оны суурь түвшинөөс 19 тээврийн хэрэгслээр гаралтаар буюу 4.1%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.




*Зураг №4 Өнөөгийн байдал*




*График №1. Тээврийн хэрэгслийн тоо*

**Байгальд ээлтэй цахилгаан автобусны хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025.07.08-ны өдрийн 192/ШШ2025/05784 дүгээр шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын "Шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай" 2025.09.26-ны өдрийн А/1349 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж захиалагчийн хяналтыг тавьж БНХАУ-д 2023 онд үйлдвэрлэгдсэн SKYWELL NJL6106BEV загварын их багтаамжийн 15 ширхэг бүрэн цахилгаан автобус болон 11 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжүүдийг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Уг 15 ширхэг автобус нь нийтийн тээврийн 14 чиглэлд үйлчилгээ үзүүлж байна.

Үүнд:Ч:25, Ч:28, Ч:39, Ч:42, Ч:57, Ч:57Б, ШҮ:1, М:1, М:2, М:4 , М:5, М:3, Х:1, Х:14, Ч:29А



*цахилгаан автобус Зураг №5*



*цахилгаан автобус Зураг №6*

**Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх**

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Юүтонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын их багтаамжийн 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авч, Багануур болон Багахангай дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг хангах үүднээс Х:17 Тэнгэр плаза-Багануур, Х:18 Тэнгэр плаза-Багахангай чиглэлийн үйлчилгээнд нийт 3 тээврийн хэрэгсэл, Чингис хаан олон улсын нисэх буудал руу Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар", ШҮ:4 "Сүхбаатарын талбай-Чингис хаан ОУНБ" гэсэн 3 чиглэлд нийт 7 тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлсэн.




*Чиглэлийн зураг №7*




*Чиглэлийн зураг №8*




*Чиглэлийн зураг №9*




*Чиглэлийн зураг №10*

**Гэр хорооллын 5 чиглэлд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх**

Нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр баригдсан гэр хорооллын дундах авто замын нөхцөл байдлыг газар дээр нь судалж холбогдох төлөвлөлтийг боловсруулсан. Судалгаагаар СХД-ийн 14, 21, 31, 43-р хороо БГД-ийн 10, 22-р хороо БЗД-ийн 17,18,19,27-р хорооны 11 байршилд дунд оврын тээврийн хэрэгслээр үйлчилгээг хүргэх боломжтой байна гэж дүгнэж холбогдох төлөвлөлтийг боловсруулсан.

Сонгинохайрхан дүүргийн 31 дүгээр хорооны иргэдийн нийтийн тээврээр зорчих эрэлтийг хангах зорилгоор судалгааг хийж, чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан тус газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Д:4 "Хайрханы шинэ эцэс-Алтай-Цамбагарав-176-р цэцэрлэг" чиглэлийн замналд өөрчлөлт оруулан 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс дунд багтаамжийн 1 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн.




*Чиглэлийн зураг №11*

Мөн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор Баянзүрх дүүргийн 10, 24, 35 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээ хүрээгүй суурьшлын бүсийн авто замын нөхцөл байдал, зорчих эрэлтийн судалгааг хийж, чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан тус газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/106 дугаар тушаалаар Д:1 "Шархад-Хангамж-Ботаник", Д:11 "Офицеруудын ордон-Цахлай-Баянзүрх дүүргийн 24-р хороо", Д:12 "Баянзүрх дүүргийн 35 дугаар хороо-Улиастайн шинэ эцэс", Д:13 "Улиастайн шинэ эцэс-Шархадны эцэс" чиглэлүүдийн замналыг баталж, 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс дунд багтаамжийн 7 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн.




*Чиглэлийн зураг №12*



*Чиглэлийн зураг №13*



*Чиглэлийн зураг №14*



*Чиглэлийн зураг №15*

**Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар хуралдаанаар Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах 25/14 дүгээр тогтоолыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж иргэд 1000 төгрөгөөр хугацаа харгалзахгүйгээр өдөрт 4 удаа зорчих боломжтой болсон. Нийтийн тээврээр зорчсон төлбөрийг зориулалтын картаас гадна банкны карт, гар утасны аппликейшн, QR код, бэлэн мөнгөөр төлөх боломжийг бүрдүүлэн ажилласнаар Нийтийн тээврийг хөгжүүлэх санд 2025 оны эхний 10 сарын байдлаар 2024 онд их багтаамжийн автобус худалдан авсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас "Нийтийн тээврийн хэрэгслийг төлбөртэй ашиглуулах гэрээ"-ний дагуу 9,023.3 сая төгрөг, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын санхүүжилтээс элэгдлийн зардалд 17,727.0 сая төгрөг, нийт 26,750.3 сая төгрөг төгрөгийг суутгаж, мөн улсын төсвийн хөрөнгөөр 2009 онд худалдан авсан 400 ширхэг автобусны өр төлбөрөөс автобус худалдан авсан Сутайн буянт ХХК, Автобус нэгдэл ХХК, Эрдэмтранс ХХК нийт 324.0 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Дээрх санд төвлөрсөн орлогоос 2025 онд хот орчмын зориулалттай их багтаамжийн 10 автобус, тусгай тоноглолтой 2 автобус, их багтаамжийн цахилгаан 15 ширхэг автобус, 11 ширхэг цэнэглэх төхөөрөмж, зогсоолын чиглэлийн мэдээллийн зураглалын үнэ төлбөр зэргийг шийдвэрлэсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын зардлын санхүүжилтийг "Үр дүнд суурилсан үнэлгээ" /KPI/ тогтолцоонд шилжүүлэх цогц арга хэмжээ авах тооцоо судалгаа хийж, санал боловсруулж, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/344 дүгээр захирамжаар Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайгаар ахлуулан байгуулсан, Ажлын хэсэг 2025 оны 03 дугаар сарын 15, 04 дүгээр сарын 15, 08 дугаар сарын 19-ний өдрүүдэд Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл, салбарын холбоодын төлөөлөлтэй уулзаж "Үр дүнд суурилсан үнэлгээ"-ний талаар мэдээлэл өгч, санал солилцсон. "Үр дүнд суурилсан үнэлгээ" (KPI) тогтолцоонд шилжүүлэх системийн нэмэлт хөгжүүлэлтийг Улаанбаатар смарт карт ХХК, Ай Си Ти групп ХК-ийн системүүдэд хийгдэж эхлээд байна. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын зардлын санхүүжилтийг "Үр дүнд суурилсан үнэлгээ" /KPI/ тогтолцоонд шилжүүлэх ажлын ачаалал, хяналтын чиг үүргээс хамаарч Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайгийн саналаар ажлын хэсгийн ахлагчаар Автозамын түгжрэлийг бууруулах төсөл, хөтөлбөрийн зохицуулагч Д.Бадарсанг ажиллуулах саналыг гаргаж, захирамжид өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.



*Албан бичиг зураг №16*



*Албан бичиг зураг №17*



*Ажлын хэсгийн хурал зураг №18*

**Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох**

Тайлант хугацаанд зорчих эрэлт, зорчигч урсгалын тооцоо судалгаанд үндэслэн нийт 12 чиглэл шинээр нээж, 14 чиглэлд өөрчлөлт оруулсан байна. Үүнээс богино эргэлтийн 14 чиглэл, гэр хорооллын суурьшлын бүсэд үйлчилгээг хүргэсэн 8 чиглэл байна.




*Чиглэлийн зураг №19*




*Чиглэлийн зураг №20*

Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор шинэ суурьшлын бүсийн авто замын нөхцөл байдал, зорчих эрэлтийн судалгааг хийж, чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан дунд багтаамжийн 7 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн.



Чиглэлийн зураг №21




Чиглэлийн зураг №22

Нийтийн тээврийн хэрэгслийн хүлээгдлийн хугацаа бууруулах зорилгоор ачаалалтай зорчигч урсгал ихтэй автобусны зогсоолуудаас 14 богино эргэлтийн чиглэлүүдийн төлөвлөлтийг хийсэн.




Чиглэлийн зураг №23




Чиглэлийн зураг №24

Нийтийн тээврийн хэрэгслийн хүлээгдлийн хугацааг бууруулах, иргэдийн зорчих эрэлт хэрэгцээг хангах, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 14 чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан.

Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны дарга, Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-ын захирал нарын хамтарсан А/72, А/78, А/34 дугаар тушаалаар 2025-2026 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолыг чөлөөлөх, замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах арга хэмжээ авч, хэрэгжүүлэх шуурхай ажлын багийн бүрэлдэхүүн, ажлын удирдамж батлагдсан.



*Шуурхай ажлын багийн бүрэлдэхүүн, ажлын баг зураг №25*

Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны дарга, Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-ын захирал нарын хамтарсан А/72, А/78, А/34 дугаар тушаалаар 2025-2026 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолыг чөлөөлөх, замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий

шуурхай ажиллагааны баг байгуулагдсантай холбоотой 2025 оны 08 дугаар сарын 18-аас 09 дүгээр сарын 11-ний өдрийг дуусталх хугацаанд Нийтийн тээврийн бодлогын газрын Хяналт, шалгалтын хэлтсийн дарга Ц.Мягмар, Тээврийн бодлого судалгааны хэлтсийн Судалгаа шинжилгээний мэргэжилтэн Б.Даваадолгор нар ажилласан.

Шуурхай ажиллагааны багийн үүрэг чиглэлийн дагуу Замын хөдөлгөөний удирдлагын төвийн Хөдөлгөөн зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, Тээврийн цагдаагийн алба хаагч нартай хамтран Энхтайваны өргөн чөлөөнд хөдөлгөөнд оролцож буй нийт 2206 нийтийн тээврийн хэрэгслийг 1 дүгээр эгнээгээр чөлөөтэй нэвтрүүлэх зохицуулалт хийсэн.




*График №2. 1-р эгнээг чөлөөлүүлж нэвтрүүлсэн тээврийн хэрэгслийн тоо*

Авто замын түгжрэлээс шалтгаалан нийт 12 нийтийн тээврийн хэрэгслийг богино эргэлт хийж, зохицуулалт хийсэн.




*График №3. Автобусны тоо*

Автотээврийн хяналтын улсын байцаагч, шалгагч нар шугам замын хяналтаар нийтийн тээврийн чиглэлийн автобусны зогсоол дээр удаан зогсож буй нийт 2048 тээврийн хэрэгслүүдийн зөрчлийг илрүүлж E police аппликейшнээр илгээсэн.




*График №4. Илгээсэн зөрчлийн тоо*

Автотээврийн хяналтын улсын байцаагч, шалгагч нар шугам замын хяналтаар нийтийн тээврийн чиглэлийн автобусны зогсоолд түр болон удаан зогсож буй нийт 2920 тээврийн хэрэгслүүдийг тус тус чөлөөлүүлсэн.




*График №5. Тээврийн хэрэгслийн тоо*

Автотээврийн хяналтын улсын байцаагч нар түгээлт, хүргэлтийн үйлчилгээний 73 автомашин шалгаж, мэргэшсэн жолоочийн үнэмлэхгүй, цагийн хуваарь зөрчсөн, зөвшөөрлийн хугацаа дууссан зэрэг 37 зөрчил илрүүлж холбогдох арга хэмжээг авсан.

Нийтийн тээврийн үйлчилгээний М:1 "5 шар-Офицеруудын ордон" чиглэлийн үндсэн үзүүлэлт болох ашиглалтын хурд өмнөх 7 хоногтой харьцуулахад 18%-иар өссөн.




*График №.6 Ашиглалтын хурд*

Нийтийн тээврийн хэрэгслээр 2025.08.18-24-ны хооронд 2,392,029, 2025.09.01-07-ны хооронд 3,482,726 зорчигч зорчсон бөгөөд 31%-иар өссөн, М:1 "5 шар-Офицеруудын ордон" чиглэлийн тээврийн хэрэгслээр 2025.08.18-24-ны хооронд 125,371, 2025.09.01-07-ны хооронд 261,734 зорчигч зорчсон бөгөөд 52%-иар өссөн. /НИЙТИЙН ТЭЭВРИЙН УДИРДЛАГЫН ДЭД СИСТЕМИЙН ТООН МЭДЭЭЛЛЭЭР/




*График №7 Зорчигчийн тоо*

Энхтайваны өргөн чөлөөний 1 дүгээр эгнээний М:1 "5 шар-Офицеруудын ордон" чиглэлийн үндсэн үзүүлэлт болох ашиглалтын хурдыг 2024 оны мөн үетэй харьцуулахад 22%-иар өссөн үзүүлэлттэй байна.




*График №8.Тоон үзүүлэлт*

Нийтийн тээврийн үйлчилгээний зорчигч урсгал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6%-иар өссөн. /НИЙТИЙН ТЭЭВРИЙН УДИРДЛАГЫН ДЭД СИСТЕМИЙН ТООН МЭДЭЭЛЛЭЭР/




*График №9.Тоон үзүүлэлт*

Нийтийн тээврийн үйлчилгээний зорчигч урсгал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4%-иар өссөн. . /НИЙТИЙН ТЭЭВРИЙН УДИРДЛАГЫН ДЭД СИСТЕМИЙН ТООН МЭДЭЭЛЛЭЭР/ 9 сарын эхний 7 хоногийн мэдээ




*График №10.Тоон үзүүлэлт*

М:1 “5 шар-Офицеруудын ордон” чиглэлийн үндсэн үзүүлэлт болох ашиглалтын хурд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20%-иар өссөн.




*График №11.Тоон үзүүлэлт*

**Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх**

2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийн тээврийн бүртгэлийн санд 1311 тээврийн хэрэгсэл байгаагаас 76.9% буюу 1009 автобус нь тэргэнцэртэй иргэдэд зориулагдсан нам шалтай, тусгай зориулалтын зорчигчийн хэсэг, бэхэлгээ хийгдсэн, дуут зарлан мэдээлэгч, лед дэлгэц, хяналтын камер зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэний зорчих нөхцөлийг хангасан тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Тоноглогдсон тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл Skywell - 96, Golden dragon - 282, Yutong - 631 байна. Үүнээс Yutong - 631 автобус нь хараны бэрхшээлтэй иргэдэд дуут зарлан мэдээлэгч тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.



*Ззураг №26*



*Зураг №27*



*Зураг №28*



*Зураг №29*



*Зураг №30*

**Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гараш барих**

Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гарaашийн барилгын зураг төслийг 2022 онд "Эрхэс констракшн" ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектураар батлуулсан.

Багануур дүүргийн "Тээвэр зохицуулалтын алба" ААТҮГ-ын Нийтийн тээврийн гарaашийн барилга барих ажлыг 2025 онд эхлүүлэхээр 1 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр "Наран босголт" ХХК шалгарсан. Тус компани барилгын ажлыг эхлүүлэхээр болсон ч их багтаамжийн автобус гарааш руу орох, гарах үед зай талбай хүрэлцэхгүй байсан тул байршлын схемийн хуудаст заасан координатыг 3-4 метр зөөж шилжүүлэхээр Багануур дүүргийн Засаг Даргын Тамгын Газраас Хот

байгуулалт, хотын стандартын газарт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 04/441 дүгээр албан бичгээр хүсэлт хүргүүлсэн.

Орон нутгийн төсвийн 3,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гараашны барилгын зураг төслийг 2022 онд "Эрхэс констракшн" ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектураар батлуулсан.

Багануур дүүргийн "Тээвэр зохицуулалтын алба" ААТҮГ-ын Нийтийн тээврийн гараашны барилга барих ажлыг 2025 онд эхлүүлэхээр 1 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр "Наран босголт" ХХК шалгарсан.

Ажлын явц одоогийн байдлаар 35 хувийн гүйцэтгэлттэй байна. Үүнд:

- Төмөр бетон карказ угсралтын ажил дууссан.

- Дээвэр хийх ажил дууссан.

- Төмөр багана, дам нуруу, холбоос угсрах ажлууд дууссан.

Мөн Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай 2025.08.24-ний өдөр Багануур дүүрэгт ажиллаж нийслэлийн төсвийн 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй том оврын 10 автобус багтаах чадалтай нийтийн тээврийн дулаан авто зогсоолын барилгын явцтай танилцсан.



*Зураг №31*



*Зураг №32*



*Зураг №33*



*Зураг №34*

--oOo--

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

# НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР





## НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ





2025.11.25

# Цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх дэд станц барих бэлтгэл хангах

| № | Байршил | Дүүрэг хороо | Газрын асуудал | Техникийн нөхцөл | Цэнэглэгчийн тоо / ширхэг / |
|---|---|---|---|---|---|
| 1 | Зорчигч тээврийн нэгтгэл 1-р бааз | Хан-Уул дүүрэг 3-р хороо | | Гарах боломжгүй | 10 |
| 2 | Зорчигч тээврийн нэгтгэл 2-р бааз | СХД 19-р хороо | | Теникийн нөхцөл гарсан / ГЕО 110/35/10 дэд станцад өргөтгөл хийнэ / | 10 |
| 3 | 5-н шар эцэс | СХД 18-р хороо | Захирамж гарсан, гэрчилгээ гараагүй | Үйлдвэр дэд станцын 10 кВ-ын РП-22-ын ТТС-6 дэд станцын I ба II секцнээс кабель шугам татаж 2*800 кВА чадалтай ХТП барихаар төлөвлөлт хийгдсэн техникийн нөхцөл гараагүй | 1 |
| 4 | БММЗ эцэс | Хан-Уул дүүрэг 3-р хороо | Захирамж гарсан, Гэрчилгээ гараагүй | 35/6 кВ-ын Эсгийлэх дэд станцаас 6 кВ-ын ТТС-9 А,Б фидерийн ТТС-9 секцнээс кабель шугам татаж 2*800 кВА чадалтай ХТП барихаар төлөвлөлт хийгдсэн техникийн нөхцөл гараагүй | 1 |
| 5 | Ботаникийн эцэс | БЗД 8-р хороо | Газар олголт хийгдэж гэрчилгээ гарсан. | 110/10 кВ-ын Амгалан дэд станцын 10 кВ-ын ТТС-2 А,Б фидерийн ТТС-2 дэд станц хоорондох кабель шугамуудыг таслаж ижил маркийн кабель шугам татаж шинээр баригдах 2*800 кВА чадалтай ХТП-г оруулж гарган тэжээхээр төлөвлөлт хийгдсэн техникийн нөхцөл гараагүй | 1 |
| 6 | КТМС | БЗД 1-р хороо | Газар олголт хийгдэж гэрчилгээ гарсан. | РП-24-өөс 10 кВ-ын Сансар А,Б фидерийн ХТП-1446,306 хоорондох А,Б кабель шугамуудыг шинээр баригдах 2*800 кВА ХТП дэд өртөөний 10 кВ-ын I ба II секцээр оруулж гаргаж тэжээхээр төлөвлөлт хийгдсэн техникийн нөхцөл гараагүй | 1 |
| 7 | Нисэхийн эцэс | Хан-уул дүүрэг | Газар олголт давхцалтай | 110/35/10 кВ-ын Яармаг дэд станц, ХБ-44-өөс 10 кВ-ын ТП17 А,Б фидерийн ХТП-4057 хоорондох кабель шугамуудыг таслаж ижил маркийн кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөний 10 кВ-ын I ба II секцийг оруулж гарган тэжээх. 2*800 кВА чадалтай ХТП барихаар төлөвлөлт хийгдсэн техникийн нөхцөл гараагүй | 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Баянхошуу | СХД | Газар олголт хийгдэж гэрчилгээ гарсан. | **35/6 кВ-ын Ваар дэд станцын 6 кВ-ын Баруун салаа фидерийн 23-р тулгуураас кабель шугам татаж 800 кВА чадалтай бетонон хийцтэй, 3 ачаалал таслагч бүхий КТПН барьж тэжээх төлөвлөлт хийгдсэн техникийн нөхцөл гараагүй** | 1 |
| 9 | Шар хадны эцэс | БЗД | ННТГ-н эзэмшил | 110/10/10 кВ-ын Улаанхуаран дэд станцын 10 кВ-ын I ба II секцнээс кабель шугам татаж 2*800 кВА чадалтай ХТП барьж тэжээх төлөвлөлт хийгдсэн техникийн нөхцөл гараагүй | 1 |
| 10 | 7-н буудлын эцэс | СБД | Газар олголт хийгдэж гэрчилгээ гарсан. | 110/35/10 кВ-ын Сэлбэ дэд станцын Согоот фидерийн 18-р тулгуураас кабель шугам татаж 800 кВА чадалтай бетонон хийцтэй, 3 ачаалал таслагч бүхий КТПН барьж тэжээх төлөвлөлт хийгдсэн техникийн нөхцөл гараагүй. | 1 |
| 11 | Тэмээтэй хөшөө 120 мянгат | Хан-Уул дүүрэг 1-р хороо | Газар олголт давхцалтай | 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцаас 6 кВ-ын Цаст фидерийн ХТП-0219 хоорондох кабель шугамуудыг таслаж ижил маркийн кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөний I секцийг оруулж гарган тэжээх. II секцийг: 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцаас 6 кВ-ын Зогсоол фидерийн ХТП-070 хоорондох кабель шугамуудыг таслаж ижил маркийн кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөний II секцийг оруулж гарган тэжээх. 2*800 кВА чадалтай ХТП барьж тэжээх төлөвлөлт хийгдсэн техникийн нөхцөл гараагүй. | 1 |

## Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх







2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 138 чиглэлд ажлын өдөр 1180, амралтын өдөр 1006 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь өдөрт үйлчлэх тээврийн хэрэгслийн гаралт 2023 оны суурь түвшин 1000 тээврийн хэрэгслийн гаралттай харьцуулахад 18%-иар, 2024 оны суурь түвшинөөс 19 тээврийн хэрэгслээр гаралтаар буюу 4.1%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

## Байгальд ээлтэй цахилгаан автобусны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025.07.08-ны өдрийн 192/ШШ2025/05784 дүгээр шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын "Шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай" 2025.09.26-ны өдрийн А/1349 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж захиалагчийн хяналтыг тавьж БНХАУ-д 2023 онд үйлдвэрлэгдсэн SKYWELL NJL6106BEV загварын их багтаамжийн 15 ширхэг бүрэн цахилгаан автобус болон 11 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжүүдийг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Уг 15 ширхэг автобус нь 14 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байна. Үүнд:

Ч:25, Ч:28, Ч:39, Ч:42, Ч:57, Ч:57Б, ШУ:1, М:1, М:2, М:4 , М:5, М:3, Х:1, Х:14, Ч:29А










240кВт, 600В, 400А хүчин чадал бүхий бүрэн цахилгаан автобус цэнэглэх 11 ширхэг цэнэглэгч төхөөрөмж нь техникийн үзүүлэлт шаардлагыг хангасан.








"Ай Си Ти" групп ХК-аас бүрэн цахилгаан 1 ширхэг автобусанд 9 төрлийн 12 ширхэг, нийт 180 ширхэг тоног төхөөрөмжийг суурилуулсан.

| № | Д/д | ААНБ-ын нэр | Улсын дугаар | Гараашийн дугаар | Марк | Тасалбар уншигч төхөөрөмж | Мобайл ДВР | Хүн тоологч камер | Алкохол мэдрэгч | Агаарын чанар хэмжигч | Урд талын хяналтын ADAS камер | Жолоочийн хяналтын DMS камер | Хойд хяналтын камер | Хяналтын камер | Жолоочийн компьютер | Кабел, холбох хэрэгслүү | Iod | Нийт суурилуулсан тоо ширхэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 |
| 1 | 1 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 21-03 УНК | 2-156 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 2 | 2 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 21-04 УНК | 2-157 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 3 | 3 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 21-10 УНК | 2-158 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 4 | 4 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 21-06 УНК | 2-159 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 5 | 5 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 21-07 УНК | 2-160 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 6 | 6 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 21-08 УНК | 2-161 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 7 | 7 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 21-09 УНК | 2-162 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 8 | 8 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 20-01 УНК | 2-163 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 9 | 9 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 20-03 УНК | 2-164 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 10 | 10 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 20-04 УНК | 2-165 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 11 | 11 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 20-05 УНК | 2-166 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 12 | 12 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 20-06 УНК | 2-167 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 13 | 13 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 20-07 УНК | 2-168 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 14 | 14 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 20-08 УНК | 2-169 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| 15 | 15 | "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ | 20-09 УНК | 2-170 | Kaivo Nanjing NJL6106BEV | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 12 |
| | | Нийт | | | | 15 | 15 | 30 | 15 | 15 | 15 | 15 | 0 | 30 | 15 | 15 | 0 | 180 |

## Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх




Өдрийн зорчигч урсгал: 257




Өдрийн зорчигч урсгал: 120

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Юутонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын их багтаамжийн 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авч, Багануур болон Багахангай дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг хангах үүднээс Х:17 Тэнгэр плаза-Багануур, Х:18 Тэнгэр плаза-Багахангай чиглэлийн үйлчилгээнд нийт 3 тээврийн хэрэгсэл, Чингис хаан олон улсын нисэх буудал руу Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар", ШҮ:4 "Сүхбаатарын талбай-Чингис хаан ОУНБ" гэсэн 3 чиглэлд нийт 7 тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлсэн.




Өдрийн зорчигч урсгал: 158




Өдрийн зорчигч урсгал: 35




Өдрийн зорчигч урсгал: 25

# Гэр хорооллын 5 чиглэлд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх




Гэр хорооллын үйлчилгээ хүрээгүй цэгт Д:1, Д:4, Д:11, Д:12, Д:13 чиглэлүүдээр үйлчилгээ хүргэж байна.

## 2.2.2.3.Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 15 өдөр Дугаар А/1111 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 7.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журам", Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/106 дугаар тогтоол-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр "Нийтийн тээврийн чиглэлийг оновчлох, хуваарь төлөвлөгөө боловсруулах систем хөгжүүлэлтийн ажил" төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Д.Батцэцэг)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг үүрэг болгосугай.

2.Захирамжид заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 650.000.000 (зургаан зуун тавин сая) төгрөгийг "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагаа" холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийтийн тээврийн бодлогын газар (Д.Отгонжаргал)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1725025341

"Нийтийн тээврийн чиглэлийг оновчлох, хуваарь төлөвлөгөөг боловсруулах систем хөгжүүлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" тухай 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1111 дугаар захирамж гарч үнэлгээний хороо байгуулагдан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер https://www.tender.gov.mn/ цахим хаягаар зарлагдсан.

### 2.2.2.3.Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох



2025 оны 08 дугаар сарын 19-ний өдөр А/344 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын зардлын санхүүжилтийг "Үр дүнд суурилсан үнэлгээ" /KPI/ тогтолцоонд шилжүүлэх аргачлалын талаар хэлэлцэж үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын үйлчилгээний үр дүнг 50-30-10-10 системээр тооцох ажлыг эхлүүлэх арга хэмжээг авахаар шийдвэрлэсэн.

Хугацаа 50% + Зам 30% + Зорчигч 10% + Орлого 10% = 100%

Цаашид KPI үнэлгээний аргачлалыг Нийтийн тээврийн чиглэлийг оновчлох, хуваарь төлөвлөгөөг боловсруулах систем хөгжүүлэлтийн ажлаас боловсруулсан загвараар нарийвчлах бөгөөд уг ажлын хэсгийг Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах төсөл, хөтөлбөрийн зохицуулагч Д.Бадарсангаар ахлуулахаар шийдвэрлэсэн.

## Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох







Тайлант хугацаанд зорчих эрэлт, зорчигч урсгалын тооцоо судалгаанд үндэслэн нийт 12 чиглэл шинээр нээж, 14 чиглэлд өөрчлөлт оруулсан байна. Үүнээс богино эргэлтийн 14 чиглэл, гэр хорооллын суурьшлын бүсэд үйлчилгээг хүргэсэн 8 чиглэл байна.

Үндсэн чиглэлүүдийн үйлчилгээний дундаж хүлээгдлийн хугацаа 10.1 минут байгаа нь 2023 оны суурь түвшинтэй харьцуулахад 33%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны дарга, Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-ын захирал нарын хамтарсан А/72, А/78, А/34 дугаар тушаалаар 2025-2026 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолыг чөлөөлөх, замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий шуурхай ажиллагааны баг байгуулагдаж 2025 оны 08 дугаар сарын 18-аас 09 дүгээр сарын 19-ний өдрийг дуусталх хугацаанд ажилласан.

Энхтайваны өргөн чөлөөгөөр нийт 39 чиглэлийн 378 тээврийн хэрэгсэл дайран өнгөрч байна.


ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ДАРГА, НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА, "ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВ" ОНӨТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ХАМТАРСАН ТУШААЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар А/72 А/78 А/34 | Улаанбаатар хот |

Шуурхай ажиллагааны баг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дугаар хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 8.4 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулийг тус тус үндэслэн тушаах нь:

1.2025-2026 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолыг чөлөөлөх, замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах арга хэмжээ авч, хэрэгжүүлэх үүрэг бүхий шуурхай ажиллагааны багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

**Дарга:**

| | |
|---|---|
| Н.Намуу | "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-ын Хөдөлгөөн зохицуулалт, хяналтын хэлтсийн дарга |

**Гишүүд:**

| | |
|---|---|
| М.Мөнгөншагай | Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга |
| Б.Эрдэнэжаргал | ЦЕГ-ын ТЦА-ны НЗХХГ-ын Хоёрдугаар хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа |
| А.Сүхбаатар | Тээврийн цагдаагийн албаны Теле хяналт, замын хөдөлгөөний удирдлагын хэлтсийн зохицуулагч Цагдаагийн ахмад |
| Б.Бат-Очир | Тээврийн цагдаагийн албаны Теле хяналт, замын хөдөлгөөний удирдлагын хэлтсийн зохицуулагч Цагдаагийн ахмад |
| Ц.Мягмар | Нийтийн тээврийн бодлогын газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга |
| А.Гансүх | Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын Тээврийн бодлого судалгааны хэлтсийн Судалгааны ажилтан |

ЗХУТ-с хөдөлгөөнд зохицуулалт хийлгэж 1-р эгнээг чөлөөлүүлж нэвтрүүлсэн тээврийн хэрэгслийн тоо




Замын хөдөлгөөний удирдлагын төвийн Хөдөлгөөн зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, Тээврийн цагдаагийн алба хаагч нартай хамтран замын хөдөлгөөний ачааллаас шалтгаалан бөөгнөрөл үүсэхээс сэргийлж, Энхтайваны өргөн чөлөөнд хөдөлгөөнд оролцож буй нийт 3247 нийтийн тээврийн хэрэгслийг 1 дүгээр эгнээгээр чөлөөтэй нэвтрүүлэх зохицуулалтыг тухай бүр хийж ажилласан.






# ЧИГЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЭГНЭЭ ЧӨЛӨӨЛӨХ АЖЛЫН ТУХАЙ

## Үр дүн

Ашиглалтын хурд км/цаг



Энхтайваны өргөн чөлөөнд нийтийн тээврийн ашиглалтын дундаж хурд 10.6 км/цаг байсан нь 12.9 км/цаг болж 18%-иар өссөн.

Нийт зорчигчийн тоо



Нийтийн тээврийн хэрэгслээр 2025.08.18-24-ны хооронд нийт 2,392,029, 2025.09.01-07-ны хооронд нийт 3,482,726 зорчигч зорчсон бөгөөд 31%-иар өссөн.

Албан хаагчид шугам замын хяналтаар илрүүлж E police апп-р илгээсэн зөрчлийн тоо




Нийтийн тээврийн бодлогын газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч, шалгагч нар шугам замын хяналтаар нийтийн тээврийн чиглэлийн автобусны зогсоол дээр удаан зогсож буй нийт 2589 тээврийн хэрэгслүүдийн зөрчлийг илрүүлж E police апп-р илгээсэн.

## Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих

Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай 2025 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Багануур дүүрэгт ажиллаж нийслэлийн төсвийн 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй том оврын 10 автобус багтаах чадалтай нийтийн тээврийн дулаан авто зогсоолын барилгын явцтай танилцсан.

Тус барилга нь он дамжин хэрэгжихээр төлөвлөгдсөн бөгөөд ажлыг энэ онд багтаан бүрэн дуусгах чиглэлийг өгч, 2026 оны нийслэлийн төсөвт үлдэгдэл 2,5 тэрбумыг тусган санхүүжүүлэхээр шийдвэрлэж, төсөвт багтаахаар болсон боловч энэ онд суусан хөрөнгө дууссан тул ажил зогсонги байдалтай байна.



- ✓Төмөр бетон карказ угсралтын ажил дууссан.
- ✓Дээвэр хийх ажил дууссан.
- ✓Төмөр багана, дам нуруу, холбоос угсрах ажлууд дууссан.
- ➢Ажлын явц 35%-тай байна.








ТАКСИ
АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА